

Цагдаагийн ерөнхий газрын даргын  
2023 оны 18. дугаар сарын 27.-ны  
өдрийн 10:00 дугаар тушаалын хавсралт

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

#### Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2023.12.27

Байгууллагын нэр:

Цагдаагийн ерөнхий газар

Албан тушаалын нэр:

Сувилагч

Ажлын цаг:

8 цаг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Нэгжийн нэр:

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТТ-9

Ажлын байрны албан ёсны байршил:

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын байр

Онцгой нөхцөл:

-Шаардлагатай үед уртасгасан цагаар ажиллах;  
-Хөрвөж ажиллах чадвартай байх;  
-Хортой нөхцөлөөс бусад орчин нөхцөлд ажиллах;  
-Байгалийн гамшиг, гол түймэр, хүн, малын гоц халдварт өвчин гарсан, гэнэтийн болон бусад аюул тохиолдсон, нийтийн эмх замbaraagүй байдал үүссэн, террорист халдлага, онц болон дайны байдал зарласан, онц ноцтой гэмт хэрэг үйлдэгдсэн зэрэг зайлшгүй тохиолдолд өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах.

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ:

Албан тушаалын зорилго:

Цагдаагийн албаны тухай, Эрүүл мэндийн тухай хууль тогтоомж, эмнэлгийн стандарт, сувиллын үйл ажиллагааны /MNS:5232:2013/ стандартыг хангаж, эрүүл мэнд, сувиллын үйл ажиллагааны чиглэлээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан чиг үүргийг хэрэгжүүлэх, эмчилгээ оношилгооны түгээмэл үйлдлүүд /MNS:4621:2008/ стандартыг баримталж, сувилагчийн өдөр тутмын сувилахуйн тусламж үйлчилгээг тэгш хуртээмжтэй чанартай хийж, эмчилгээний тоног төхөөрөмж, эд хөрөнгөд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэх.

Албан тушаалын зорилт:

1. Алба хаагч, ажилтанд эмчилгээ сувилгааг эмчилгээ үйлчилгээний түгээмэл үйлдлийн /MNS:4621:2008/ стандартыг хэрэгжүүлж, сувилахуйн 8 шатлалаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, зохион байгуулах.
2. Эмчилгээний тоног, төхөөрөмж, эд хөрөнгийг бүрэн бүтэн байлгахад хяналт тавьж, дотоод журмыг мөрдөж ажиллах.
3. Эмнэлгийн яаралтай түргэн тусламжийг цаг алдалгүй түргэн шуурхай үзүүлэх.
4. Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн албан тушаалын зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр
1 дүгээр зорилтын хүрээнд	<p>1.1. Эмчилгээ, үйлчилгээний түгээмэл үйлдлийн стандарт /MNS:4621:2008/ стандартыг баримтлан ажиллах;</p> <p>1.2. Төв байрны үйлчлэгч нарын өдөр тутмын цэвэрлэгээ, үйлчилгээнд хяналт тавьж ажиллах;</p> <p>1.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн /ХАБЭА/ тухай хуулийг дагаж мөрдөж, ажлын хувцас хэрэглэлийг бүрэн өмсөж, физик эмчилгээний тоног төхөөрөмжийг ажиллуулах;</p> <p>1.4. Эм, тариа, бусад эмчилгээний бүтээгдэхүүний бэлэн байдлыг хангаж ажиллах;</p> <p>1.5. Эм, тарианы зарцуулалтын тайланг тогтмол гаргаж, шаардлагатай эм, тариа, ороох боох материалын нөөцийг бүрдүүлэх;</p> <p>1.6. Эмчилгээний мэдээ, дүн бүртгэлийг цаг тухайд гаргаж тайлагнах;</p> <p>1.7. Эмчийн зааврын дагуу эм, тариа, ороох боох материалыг олгох, ашиглах, зарцуулах.</p>	Эмчилгээ, сувилгаа тэгш хүртээмжтэй хүрсэн байна.	Г Г, Х Г Г Г Г Г Г
2 дугаар зорилтын хүрээнд	<p>2.1. Өрөөний эд хөрөнгийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, засварлуулах болон алга болсон, эвдсэн эд хөрөнгийг холбогдох албан тушаалтанд мэдээлж, шийдвэрлүүлэх;</p> <p>2.2. Эмчилгээний тоног төхөөрөмжийн техник ашиглалтын паспортыг стандартын дагуу хөтөлж, эд хөрөнгийг бүртгэх;</p> <p>2.3. Эмчилгээ, сувилгаанд хөтлөгдөх маягт, бүртгэлийг хөтөлж, эм, ороох боох материалын зарцуулалтыг гаргах;</p> <p>2.4. Албаны байр, тавилга, хэрэгсэл, эд зүйлсийг цэвэр, цэмцгэр, эмх цэгтэй ашиглаж, техник, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах;</p>	Сувиллын эд хөрөнгө, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал хангагдана.	Г Г Г Г

3 дугаар зорилтын хүрээнд	3.1. Амилуулах суурь тусlamж үзүүлэх чадвар дадлыг эзэмшсэн, шаадлагатай үед анхны тусlamж үзүүлэх ажлыг хэрэгжүүлэх; 3.2. Амилуулах суурь тусlamж үзүүлэх тоног төхөөрөмжийг хариуцан ажиллуулах; 3.4. Цагдаагийн төв байгууллагын өрөө, тасалгаанд ариутгал, халдвартгуйжүүлэлт хийх;	Яаралтай түргэн тусламжийн чанар сайжирсан байна.	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	4.1. Гүйцэтгэлийн төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайланг 7 хоног, сар, улирал, жилээр гаргаж удирдлагад танилцуулах; 4.2. Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны Архив, албан хэрэг хөтлөх /код 120/ журмын хэрэгжилтийг хангах; 4.3. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж, байгууллагын ажилтнууд болон харилцагч, үйлчлүүлэгчид, иргэдтэй зөв боловсон харьцах, ёс зүйн зөрчил, дутагдал гаргахгүй байх; 4.4. Авилга, хүнд суртлаас ангид байж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, шударга ёсыг эрхэмлэн, "Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг чанд мөрдөх; 4.5. Явзуу эрх ашиг сонирхлоос татгалзаж, цагдаагийн байгууллага, албаны нийтлэг эрх ашиг сонирхлыг эрхэмлэн ажиллах.	Цагдаагийн алба хаагчийн хуулиар хүлээлгэсэн нийтлэг чиг үүргийн биелэлт хангагдана.	Г

### III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	-Тусгай дунд ба түүнээс дээш боловсролтой байх		
Мэргэжил	-Сувилахуй /091301/		
Мэргэшил	-Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх; -Мэргэжлээрээ жил бүр багц цагийн сургалтад хамрагдсан байх.		
Туршлага	- Мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан байх.		
Үр чадвар	Дүн шинжилгээ хийх	-Албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах; -Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах.	
	Асуудал шийдвэрлэх	-Байгууллагын чиг үүргийн хэрэгжилтэд өөрийн ажил үүргийн оруулах хувь нэмэр, оролцоог ойлгодог; -Өөрийн үйл ажиллагааны үр дунд хяналт тавьж чаддаг.	
	Багаар ажиллах	-Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонгой хуваалцаж хамтран ажиллах; -Багийн хүрээнд өөрт ногдсон үүргээ гүйцэтгэх.	
	Бусад	-Гадаад хэл /орос, англи хэл/, мэдээллийн технологийн болон бусад зайлшгүй шаардлагатай үр чадвар.	

### IV. АЛБАН ТУШААЛЫН ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

**Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:**

-Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын Эрүүл мэнд, сэтгэл зүйн тасгийн дарга

**Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо:**

-Батлагдсан орон тоогоор

**Бусад харилцах субъект:**

**Шууд харилцах байгууллага:**

Хариуцсан асуудлаар бусад яам, агентлагийн албан тушаалын адил болон түүнээс доош зэрэглэлтэй албан тушаалтан;

**Шууд бус харилцах байгууллага:**

Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хуулийн этгээд, иргэн;

/Эдгээртэй харилцахдаа Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомж, үйл ажиллагааны журмын холбогдох заалтыг баримтална./

**V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ:**

**Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:**

Албан тушаал: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭД ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Т.ГАНЗОРИГ

20~~23~~ оны 27 дугаар сарын 27-ны өдөр

**Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:**

Байгууллагын нэр: .....

Шийдвэрийн огноо: .....

Дугаар: .....

**Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:**

Байгууллагын нэр: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Шийдвэрийн огноо: 2023. 12. 27

Дугаар: 8/401

(тамга/тэмдэг)

ДАРГА,

ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Т.СУХБОЛД

2023. оны 27 дугаар сарын 27-ны өдөр

ТАНИЛЦСАН:

**Албан тушаалтан:**

20..... оны .... дугаар сарын ....-ны өдөр